



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 1 дүгээр сарын 21 өдөр Дугаар 06

Хэрлэн сум

VI ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 6 дугаар хуралдаан 2021 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 14:00 цагт аймгийн Дорнод их сургуулийн хурлын танхимд 82,6 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Сум, багийг аймгийн Онцгой комиссын гишүүдэд хариуцуулах талаар хуваарь танилцуулах,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

2.Улаанбаатар хотоос татан авах иргэдийн тоо, нэрсийг танилцуулах,

Эрүүл мэндийн газар

3.Улаанбаатар хотоос иргэдийг татан авахтай холбогдуулан Хөлөнбуйр сумын хяналтын цэгт ажиллах хүч нэмэгдүүлэх талаар танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

4.Улаанбаатар хотоос иргэдийг татан авах зам маршрутыг танилцуулах,

Тагнуулын газар

5.Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичгийг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Аймгийн Онцгой комиссын нийт гишүүдэд:

1.1.Улаанбаатар хотоос татан авалтаар ирсэн Дорнод аймгийн иргэдийн тусгаарлалтад байх хугацаанд хяналт тавьж ажиллах аймгийн Онцгой комиссын гишүүд, агентлаг, байгууллагын удирдлагуудын хуваарийг батлав,

1.2.Хуваарийн дагуу Онцгой комиссын гишүүд сумын Засаг дарга нартай холбогдож татан авалт хийх автомашины бэлэн байдлыг хангуулахыг,

1.3.Хариуцсан сумын Онцгой комисстой өдөрт 3-4 удаа холбогдож зөвлөмж, чиглэл өгч мэдээлэл солилцож байхыг,

/  / М.Бадамсүрэн
/  / Э.Ганжигүүр

1.4.Тусгаарлалтад орсон иргэнтэй цуг байгаа гэр бүлийн гишүүдийн албан байгууллагын удирдлагуудад 7 хоногийн хугацаанд цалинтай чөлөө олгох талаар санал хүргүүлж ажиллахыг,

Хоёр.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

2.1.Улаанбаатар хотоос Дорнод аймгийн иргэдийн татан авах ажил гүйцэтгэж буй хот хоорондын тээврийн "Айсвн" ХХК-д жолооч, зорчигч нарт халдвар хамгааллын дэглэм мөрдүүлж ажиллах талаар албан бичиг хүргүүлэхийг,

2.2.Улаанбаатар хотоос ирсэн иргэний гэрт ахлах ангийн сурагч байгаа тохиолдолд тухайн сурагчийг сургалт, давтлаганд хамруулахгүй байх, өрхийн эмнэлгүүдээс баг тус бүрт эмч томилох, томилогдсон эмч нарыг ажиллуулах хуваарийг Цагдаагийн газрын шуурхай дуудлагын 102, Онцгой байдлын газрын 101, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 103, бусад шаардлагатай дугааруудын талаар иргэдэд өгөх зөвлөмжид тусгахыг,

2.3.Аймгийн Онцгой комиссын 6 дугаар хуралдаанд ирж амжаагүй гишүүдэд хуралдаанаар өгсөн үүрэг чиглэл, мэдээллийг дахин хүргэхийг,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат,
АЗДТГ-ын Хууль эрхзүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Баяржаргал-д:

2.4.Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комисс, аймгийн Онцгой комисс, Засаг даргын шийдвэрээр гарсан эрхзүйн актыг нэгтгэж бэлтгэн гэрийн тусгаарлалтын үед хяналт тавьж ажиллах багийн ахлагч нарт хүргүүлэхийг,

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр-д:



2.5.Улаанбаатар хотоос Дорнод аймгийн иргэдийн татан авах ажил гүйцэтгэж буй хот хоорондын тээврийн жолооч нарт бээлий өмсгөх, амны хаалт зүүх, хамгаалалтын хувцас өмсөх, тусгаарлах хөшиг хийх талаар чиглэл өгөхийг,

2.6.Улаанбаатар хотоос ирэх иргэдийг хот хоорондын тээврийн хэрэгсэлд сум, баг тус бүрээр суулгаж зохион байгуулалтын арга хэмжээ авахыг,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

3.1.Улаанбаатар хотоос Дорнод аймгийн иргэдийн татан авахдаа баг багаар нь буулгах, тээврийн хэрэгсэлд түргэн шуурхай ариутгал хийх,

Дөрөв.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

/  / М.Бадамсүрэн
/  / Э.Ганжигүүр

4.1.Аймгийн Засаг даргын 2020 оны А/559 дугаар захирамжаар баталсан "Орон нутагт зорчигч тээврийн үйлчилгээг зохицуулах түр журам" шинэчлэн боловсруулахыг,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Мөнхтөр нарт:

4.2.Тусгаарлагдсан иргэдэд хяналт тавьж буй тээврийн хэрэгслийн салхины шил, арын шилэнд таних тэмдэг байршуулж үүрэг гүйцэтгүүлэхийг,

4.3.Хяналт тавин ажиллаж байгаа тээврийн хэрэгслийг бүртгэлжүүлж мэдээллийг аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт танилцуулахыг,

Тав.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа нарт:

5.1.Хөлөнбуйр сумаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн "Хүргэлтийн хоолны үйлдвэрлэл үйлчилгээг эхлүүлэх" хүсэлтийн дагуу Хөлөнбуйр сумын хоолны үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг 15 газрын үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн аймгийн Онцгой комиссын дэргэдэх Шуурхай штабт танилцуулж шийдвэрлүүлэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА М.БАДАМСҮРЭН

БҮСИЙН ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН
ГАЗРЫН АХМАД Э.ГАНЖИГҮҮР

